

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 тоот тушаалын
7 дугаар хавсралт

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН 2021 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

2021.12.10

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилт от түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Хувь
1	Хүнс хөдөө аж ахуйн газрын болон сумдын хөдөө аж ахуйн тасгийн хүний нөөцийн судалгааг гарган тогтвор сууршилтай ажиллах нөхцлийг хангах.	ОНТ	Боловсон хүчний хүрэлцээ хангамжийн хувь	40	45	ХХААСалбарын мэргэжилтэн боловсон хүчин 57 байхаас 32 албан хаагч ажиллаж, мэргэжилтэй боловсон хүчний хангамж 56,1 хувьтай байна. ХААИС-д мал зүйч чиглэлээр 5 оюутан суралцаж байна. 1 оюутны сургалтын төлбөрийг аймгийн Засаг даргын нөөцөөс шийдвэрлүүлсэн.	100
		0	3-аас дээш жил тогтвор сууршилтай ажиллаж буй албан хаагчид	23	24	ХХААГазарт 9, сумдын ХААТасагт 14 албан хаагч, нийт ХХААХҮСалбарт 3-аас дээш жил тогтвор сууршилтай ажиллаж байгаа 23 албан хаагч байна.	
1.1	ХХААСалбарт шаардлагатай боловсон хүчний нарийвчилсан судалгааг гаргах.	0	Судалгаа гарсан эсэх	Үгүй	Тийм	ХХААГазарт ажиллаж байгаа 19 албан хаагч, сумдад ажиллаж буй 20 албан хаагчдын нарийвчилсан дэлгэрэнгүй судалгаагаар ажиллаж байна. Сумдын Хөдөө аж ахуйн тасагт нийт 45 албан хаагч ажиллахаас 20 албан хаагч байгаагаас 14 албан хаагч нь 3-аас дээш жил тогтвор суурьшилтай ажиллаж 25 албан хаагч дутагдалтай.	100
1.2	Төрийн албан хаагчдыг орон зай, цаг хугацаанаас үл хамааран богино болон дунд хугацааны сургалтад бүрэн хамруулж мэдлэг ур чадварыг дээшлүүлэх.		Сургалтад хамрагдсан албан хаагчид	10	18	Нийт 24 удаагийн цахим сургалтад давхардсан тоогоор 192 албан хаагч хамрагдаж гэрчилгээ, сертификат авсан.	100

1.3	Ажилтан албан хаагчдын цалинг нэмэх, зэрэг дэв, ур чадвар зэрэг хүний нөөцтэй холбоотой шийдвэрийг гарган хэрэгжүүлэх.		Цалин хөлсний нэмэгдэл олгосон ажилчдын тоо		5	Газрын даргын 2021 оны А/ 07 тоот тушаалаар төрийн захиргааны 5, төрийн үйлчилгээний 1 албан хаагчийн цалингийн шатлалыг ахиулсан. Урамшуулал, цалин хөлсний нэмэгдэлд нийт 18,1 сая төгрөг зарцуулаад байна.	100
			Зэрэг дэв ахиулсан албан хаагчид	0	5	Төрийн албаны салбар зөвлөлийн 2021 оны 15 дугаар тогтоол, ХХААГ-ын даргын А/10 тоот тушаалаар 5 албан хаагчийн зэрэг дэвийг тус тус ахиулсан.	
2	Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын 2021 оны үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх	0	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн хувь	88,7	89,0	ЗГҮАХ- 100 АЗДҮАХ- 89,3 Үндсэн чиглэл- 88,4 АЗДТГ-ын зөвлөмжийн хэрэгжилт- 100 %-тай хэрэгжлээ. Бодлогын баримт бичгийн хэрэгжилт 94,4%-тай хэрэгжлээ.	100
2.1	Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтүүдэд үнэлгээ хийх	0	Үнэлгээ хийсэн БББ-ийн тоо	6	6	ХХААХҮСайд- Аймгийн Засаг дарга, Аймгийн Засаг дарга ХХААГ-ын дарга, ХХААХҮСайд-ХХААГ-ын даргатай байгуулсан гэрээний хэрэгжилтэнд хагас жил, жилийн эцсээр үнэлгээ хийн ажилласан. 3-р улирал, хагас жил, жилийн эцэс, байдлаар хэрэгжилт удаашралтай байгаа заалтуудыг нэгтгэн ХХААГ-ын даргын зөвлөлийн хуралд танилцуулсан. Жилийн эцсийн байдлаар ХХААХҮСайд-АЗД-тай байгуулсан гэрээ-89,1 Аймгийн Засаг дарга ХХААГ-ын даргатай байгуулсан гэрээ 93,2 %-ийн гүйцэтгэлтэй тус тус хэрэгжлээ.	100
2.2	Байгууллагын ил тод нээлттэй байдалд хяналт үнэлгээ хийх	0	Үнэлгээний тоо	4	4	Байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд ил тод сурталчилж байгаа эсэхэд сар бүр хяналт тавьж 12 удаа үнэлгээ хийсэн. Нийт 67 мэдээлэлийг байршуулан байгууллагын үйл ажиллагааг иргэд олон нийтэд сурталчилсан байна.	100
3	Авилгаас урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах,	0	Хувь	100	100	Авлигаас урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөрийн төлөвлөгөөг 11 дүгээр сарын	100

	сургалт суртчилгааг зохион байгуулах.					байдлаар 100%-тай хэрэгжүүлэн ажилласан.	
3.1	Байгууллагын үйл ажиллагаанд үнэлгээ хийлгэх.	0	Too	1	2	Байгууллагын үйл ажиллагааг төрийн бус байгууллагаар үнэлүүлэх хөрөнгө байхгүй тул өөрсдийн нөөц боломжийг ашиглан асуумж бэлтгэн иргэдээс цахимаар болон санал асуулгын хуудсаар 2 удаа судалгаа авлаа. Судалгаанд 15 сумын 60 иргэн оролцож манай байгууллагын үйл ажиллагааг хангалттай сайн гэж үнэлсэн байна.	100
3.2	Удирдах албан тушаалтнуудын хамаарал бүхий этгээдүүдийн ажил эрхлэлтийн судалгааг гаргаж ил тод мэдээллэх	0	Too	1	2	Байгууллагын удирдах 4 албан тушаалтнуудын хамаарал бүхий этгээдүүдийн судалгааг авч нэгтгэн цахим хуудсанд ил тод мэдээллэсэн.	100
3.3	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах.		Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	90	90	 110 дугаарын сурталчилгааны шторкыг 9 удаа байгууллагын цахим хуудсанд байршуулан сурталчилсан. Дундговь авлигагүй хөгжинө уриалгад нэгдэн шударга ёс хөгжил дэвшилд 110 самбараар АТГ-ын үйл ажиллагааг ил тод мэдээллэн ажиллаж байна. 2021 онд нийт 16 заалттай төлөвлөгөөг батлуулан 100 хувьтай хэрэгжсэн. 	100
4	Байгууллагын үйл ажиллагааг захиргааны болон хүний нөөцийн удирдлагаар хангах.	0	Хуулийн дагуу сул орон тоо нөхөгдсөн эсэх	1	2	Мал үржлийн албаны 2 сул орон тоонд Б.Наранцэцэгийг Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын хамтарсан 34/31 тоот тушаалын дагуу шилжиж, Д.Бямбадорж Төрийн аланы шалгалт өгч тэнцэн ажлын байранд томилогдон ажиллаж байна.	100
		0	Хүний нөөцийн бодлогын	80	85	Байгууллагын хүний нөөцийн хөтөлбөр 94,5 %-тай хэрэгжлээ.	

			хэрэгжилтийн хувь				
4.1	Төрийн албан хаагчдын “Монгол бичиг” мэдлэгийг дээшлүүлж албан хаагчдыг бүрэн хамруулах.		Зохион байгуулсан сургалтын тоо	0	3	“Үндэсний бичиг-III” ажлын хүрээнд ХХААГ-ын 2021 оны төлөвлөгөөний хэрэгжилт 11 дүгээр сарын байдлаар 90% байна. Аймгийн Засаг дарга бөгөөд хэлний бодлогын салбар зөвлөлийн даргын 1/93 албан тоотын дагуу байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд төрийн албан хаагчдын монгол хэл, бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх заалтыг оруулж хэрэгжилтийг тооцон ажиллаж байна. “Дундговь аймгийн Төрийн албан хаагчид” facebook цахим хаягт байгууллагын 17-н албан хаагч гишүүн болж нэгдэн Д.Төмөр багшийн “Монгол бичгээ 15 хоногт бие даан сурах, анхны хичээл”-үүдийг байгууллагаараа тусгай цаг гарган үзэж судлан 7 хоног бүрийн цахим сорилд албан хаагчид бүрэн хамрагдсан. Эрдмийн Далай цогцолбор сургуулийн сургагч багш Л.Уранбайгаль хуваарийн дагуу байгууллагын албан хаагчдад зориулсан Монгол бичгийн модуль сургалтыг 5-н удаа танхимаар хийж гэрээг нийт-17 албан хаагчтай байгуулсан. “Хүмүүн бичиг” сониныг захиалж албан хаагчид судалж байна. Мөн үндэсний бичиг-III аяны хүрээнд байгууллагын “Цэвэр бичигтэн” уралдааныг зохион байгуулсан. 1-р байранд Ж.Шинэ-Уянга 2-р байранд П.Алтаннавч 3-р байранд Э.Эрдэнэтунгалаг нар тус тус шалгарсаныг шагнаж урамшууллаа. Шагналыг байгууллагын дундын сангаас 50,000 мянган төгрөгийг гаргасан.	100
4.2	Байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарыг баяжуулж,		Мэдээ,	50	70	Байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарыг баяжуулж, шинэ мэдээ, мэдээллээр тогтмол шинэчлэн, нийт 67	95,7

	цаг үеийн ажлуудын талаар мэдээлэл хүргэх.		мэдээллийн тоо			мэдээлэл, байршуулж, иргэдэд шуурхай хүргэн ажиллаа.	
4.3	Архив, албан хэрэг хөтлөлтийн стандартыг хэрэгжүүлэх 3 сарын аян зохион байгуулах.	0	Аяны хүрээнд хийх ажлын төлөвлөгөөний хэрэгжилт	0	80	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль шинээр эхлэн хэрэгжиж байгаатай холбогдуулан "Архив албан хэрэг хөтлөлт"-ийн 3 сарын аяны төлөвлөгөөг боловсруулан газрын даргаар батлуулан хэрэгжилтийг 93 хувьтай ханган ажилласан. Албан хаагч нарт албан хэрэг хөтлөлт, стандартын талаарх гарын авлагыг тарааж, мөрдүүлэн ажиллуулсан. Засаг Даргын Тамгын Газрын Хууль эрх зүйн хэлтсээр тус байгууллагаас гарсан эрх зүйн актын хууль эрх зүйн үндэслэл, стандартыг хянуулж, заавар зөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж байна. Байгууллагын баримт бичиг нягтлан шалгах комиссыг газрын даргын 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/11 тоот тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Тус газрын устгах баримтын жагсаалтын судалгааг гарган баримт бичиг нягтлан шалгах комисс, Мал эмнэлгийн газрын холбогдох албан тушаалтнууд оролцон 05 дугаар сарын 20-ний өдөр архивын баримтыг ялган бүртгэлээ. Бүртгэсэн баримтыг архиваас ялган тавьж устгах баримтыг жагсаалтаар гаргалаа. Жагсаалтыг аймгийн архивын тасагт хүргэн хянуулсны дараагаар устгах ажлыг зохион байгуулна. Нийт 85 баримтыг устгах баримт бичгийн бүртгэлд бүртгэн авлаа.	100
4.4	Байгууллагын хэмжээнд “Ковид-19” халдварт цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлж, төлөвлөгөөтэй ажиллах.	Байгууллагын төсөв 0,5 сая төгрөг	Төлөвлөгөөний хэрэгжилт	-	80	Байгууллагын хэмжээнд “Ковид-19” халдварт цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангах 9 заалт төлөвлөгөөг боловсруулж хэрэгжилтийг 90 хувьтай ханган ажилласан.	100

4.5	Сул орон тооны захиалгыг төрийн албаны салбар зөвлөлд мэдээлэх.	0	Хуулийн дагуу нөхөгдсөн ажлын байрны тоо	0	2	Мал үржлийн албаны сул 2 орон тооны захилгыг төрийн албаны салбар зөвлөлийн аймгийн салбар зөвлөлд газрын даргын 2021 оны 01/23 тоот албан бичгээр хүргэн ажилласан. Байгууллагын цахим сайт болон мэдээллийн самбарт мэдээлсэн. МҮАлбаны 2 сул орон тоо хуулийн дагуу нөхөгдсөн.	100
4.6	Төрийн жинхэнэ албан хаагчийн сахилга хариуцлага, ёс зүйн хэм, хэмжээг сахих арга хэмжээг зохион байгуулах		Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	93,7	95	Ёс зүйн зөвлөлийн 2021 онд хийх 11 заалт бүхий төлөвлөгөөг боловсруулан Газрын даргаар батлуулж 95 хувьтай хэрэгжүүлэн ажиллаа. Төрийн албан хаагч бүртэй ёс зүйн гэрээг байгуулсан. Зөрчил гаргасан албан хаагч байхгүй.	100
5	Хоол, хүнс үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний салбарын хууль тогтоомж, бодлого шийдвэрийн, хэрэгжилтийг сурталчилан танилцуулах.	УТ, ОНТ, Төсөл хөтөлбөр, Хувийн хэвшил	Мэдээлэл, зөвлөгөө авсан иргэдийн тоо	20-25	30-60	Стандарт хэмжил зүйн хэлтэстэй хамтран MNS 4946:2019 хоолны газрын шинэчлэгдсэн стандарт, MNS 5021-1:2019 Жижиглэн худалдааны шинэчлэгдсэн стандартуудыг мөрдүүлэх, хэрэгжилтийг хангуулах зорилгоор 3 удаагийн хяналт шалгалтаар аймгийн төвийн 60 хоол үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ эрхлэгч иргэн ААНэгжид ажлын байранд нь зөвлөмж зөвлөгөөг өгч, гарын авлага материалаар хангаж ажиллалаа. Шинэчилсэн стандартын хэрэгжилт 90 хувьтай байна.	100
5.1	“Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн” хөтөлбөрийн хүрээнд гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний орон нутгийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх	УТ, ОНТ, Төсөл хөтөлбөр, Хувийн хэвшил	Үйлдвэрлэлийн хэмжээ /тн/	658	711,5	Орон нутгийн үйлдвэрлэлээр жилийн эцсийн байдлаар талх 48,45 тн, нарийн боов-187,4 тн, мах, махан бүтээгдэхүүн-53,4 тн-ыг тус тус үйлдвэрлэсэн байна. Мөн Ургац хураалтын мэдээгээр нийт 66,3 га-аас 419,2 тн-ыг хураан авсан. Энэ онд нийт 708,45 тн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн байна.	99,6
5.2	Орон нутгийн үйлдвэрлэлээр хүн амын мах, махан бүтээгдэхүүний	Хувийн хэвшил	Хангамжийн хувь	0,07	0,09	Эрдэнэдалай сумын “Гүн цагаан далай” хатаасан борцны үйлдвэр энэ онд 0,6 тн	100

	хэрэгцээний тодорхой хувийг хангах					бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн байна. Нийт 1,6 тн махыг үйлдвэрийн аргаар бэлтгэж, хүн амын хэрэгцээнд нийлүүлж хэрэгцээт мах махан бүтээгдэхүүний 0,09 хувийг хангасан байна.	
5.3	Орон нутгийн үйлдвэрлэлээр хүн амын талх нарийн боовны хэрэгцээний тодорхой хувийг хангах	Хувийн хэвшил	Хангамжийн хувь	11.2	13	Орон нутгийн үйлдвэрлэлээр жилийн эцсийн байдлаар талх- 105,5 тн, нарийн боов-106,2 тн, үйлдвэрлэж, хэрэгцээт гурилан бүтээгдэхүүний 12,6 хувийг хангасан байна.	0
6	Газар тариалангийн салбарын хууль тогтоомж, бодлого шийдвэрийн, хэрэгжилтийг сурталчилан танилцуулах.	УТ, ОНТ, Төсөл хөтөлбөр, Хувийн хэвшил	Мэдээлэл, зөвлөгөө авсан иргэдийн тоо	60	50	Хөдөө аж ахуйн зохистой дадал, эзэмшүүлэх, ургамал хамгааллын мэдлэг олгох сургалтад 30 тариалан эрхлэгч хамруулж ХАА-н зохистой дадал (GAP) нэвтрүүлэх Монгол улсын үндэсний стандартын мэдлэгийг олголоо. Мөн хүнсний нарийн ногоогоор орон нутгийн зах зээлийг хангах оновчтой шийдэл, стратегийг тодорхойлох зорилготой “Хамтдаа шийдье” хэлэлцүүлгийг АЗДТГ, ХХҮГ, Дэлхийн банк, Монголын тариаланчдын үндэсний холбоо, Говийн шимт ургац ТББ-тай хамтран зохион байгуулж 114 иргэнийг хамрууллаа.	100
6.1	“Хүнсний ногоо” хөтөлбөрийн 2021 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэх	УТ, ОНТ, Төсөл хөтөлбөр, Хувийн хэвшил	Нийт тариаланчдын тоо	149	154	Аймгийн хэмжээнд хаврын тариалалтын судалгаанаас үзэхэд нийт 154 тариаланч 66,3 га-д төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, малын тэжээлийн ургамал тариалсан байна. /100/	98,4
			Төмс, хүнсний ногоог тариалах хэмжээ /га/	26,8/16,2	28/17,2	Төмс 28 га, хүнсний ногоог 19,5 га талбайд тус тус тариалсан. /100/	
			Төмс, хүнсний ногоо хураан авах ургацын хэмжээ /тн/	239,4/131	256/138,2	Энэ онд төмс 233 тн, хүнсний ногоо 162,3 тн ургац хураан авсан. /95,5/	

			Хангамж /хувиар/	14,5/ 3,6	15/3,8	Аймгийн жишсэн дундаж хүн амын хэрэгцээт төмсний 14,5 хувь, хүнсний ногоо 4,5 хувийг хангаж байна.	
6.2	Хүлэмжийн аж ахуйг нэмэгдүүлэн хүн амыг шинэ ургацын хүнсний ногоогоор хангах	УТ, ОНТ, Төсөл хөтөлбөр, Хувийн хэвшил	Тариалсан талбай м ²	11569	12069	2021 онд нийт 12773 м ² талбайд хүлэмжинд тариалалт хийсэн үүнээс 1540м ² талбай бүхий өвлийн хүлэмж, 11233 м ² талбай бүхий зуны хүлэмжид тариалалт хийснээр хүлэмжийн тариалалт өмнөх оноос 1200 м ² талбайгаар шинээр нэмэгдсэн байна.	100
			Ургац тн	45	49,5	Нийт 56,6 тн ургац хураан авсан.	
			Хүлэмжийн таримлын нэр төрөл	12	14	Энэ онд шинээр яншуй, юуйцай нэмж тариалан, нийт 14 нэр төрлийн таримал тариалсан байна.	
			Хангамж хувь	3,6	3,8	Аймгийн жишсэн дундаж хүн амын хэрэгцээт хүнсний ногоо 4,5 хувийг хангаж байна.	
6.3	“Жимс, жимсгэнэ” дэд хөтөлбөрийн 2021 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэх	УТ, ОНТ, Төсөл хөтөлбөр, Хувийн хэвшил	Тариаланчдын тоог нэмэгдүүлэх	62	67	2021онд хэрэгжүүлэхээр Жимс, жимсгэнийг 1 зорилт, 5 заалт бүхий төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна. Аймгийн ЗДТГ-аас санаачлан, дэмжлэг үзүүлж, БОАЖГ, "Эх дэлхийгээ аварья жиргээ холбоо" НҮТББ-тай хамтран “Дундговιο Ногооруулъя” уриатай 15 сумын иргэдийн төлөөлөл 75 хүн оролцсон мод бут, жимс жимсгэнэ тарих арчлах хамгаалах, хүлэмжийн нарийн ногоо тариалах, цэцэг арчлах зэрэг арга зүйн болон бодит туршлага хуримтлуулах 3 өдрийн сургалтанд хамтран ажиллалаа. Энэ онд 8 тариаланч шинээр нэмэгдэн нийт 70 тариалан эрхлэгчтэй болсон байна. /100/	66,5

			Тариалсан талбай /га/	61,4	65,9	Энэ онд шинээр жимс жимсгэний тариалалт 4,2 га-аар нэмэгдэж, аймгийн хэмжээнд жимс жимсгэнийг тариалсан нийт талбай 65,6 га болоод байна. /99,5/	
			Хураан авсан ургац /тн/	4,1	4,5	Энэ онд 2,7 тн ургац хураан авсан./0/	
7	ЖДҮ, Ахуй үйлчилгээ, Хоршооны салбарын хууль тогтоомж, бодлого шийдвэрийн, хэрэгжилтийг сурталчлан танилцуулах	УТ, ОНТ, Төсөл хөтөлбөр, Хувийн хэвшил	Мэдээлэл, зөвлөгөө авсан иргэдийн тоо	80	90	90-н жижиг дунд бизнес эрхлэгчдэд салбарын холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг сурталчилж ажилласан.	100
7.1	“Ахуйн үйлчилгээний” салбарыг дэмжих” хөтөлбөрийг хэрэгжүүлэх	УТ, ОНТ, Төсөл хөтөлбөр, Хувийн хэвшил	Дэмжлэг үзүүлсэн иргэний тоо	18	20	Ахуй үйлчилгээний чиглэлээр 19 иргэнд СХСангаас санхүүгийн дэмжлэг олгосон. /95/	97,7
			Олгосон санхүүжилт сая.төг	260	230	СХСангаас 19 иргэнд 482,0 сая төгрөгний санхүүжилт олгосон. /100/	
			Шинэ болон хадгалагдсан ажлын байрны тоо	27/15	30/20	Шинээр 29 ажлын байр бий болж, 23 ажлын байр хадгалагдсан байна. /98,3/	
7.2	“Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр-III”-ийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх /ЗГ 2019 оны 362 дугаар тогтоол/	УТ, ОНТ, Төсөл хөтөлбөр, Хувийн хэвшил	Сургалт сурталчилгаанд хамрагдсан иргэдийн тоо	14	20	Улаанбаатар хотод болсон хоршооны үзүүлэх сургалтанд Сайнцаан, Хулд сумдын төлөөлөл болох 4 иргэн хамрагдсан. Мөн хоршооны шинэчлэн батлагдсан хууль болон Хоршоо хөгжүүлэх сан болж буйтай холбоотой сургалтыг Цагаандэлгэр суманд зохион байгуулагдсан нээлттэй мэдээллийн өдөрлөгөөр өгсөн. Уг сургалтанд хоршооны төлөөлөл 25 иргэн оролцсон. Энэ онд нийт 29 иргэнийг зөвлөгөө мэдээллээр хангасан. /100/	100

			Идэвхгүй хоршоодын тоог бууруулах	39	38	Сайнцагаан сумын Аравжих далай хоршоо энэ онд хоршооны тэргүүлэх гишүүд хуралдаж цаг үеийн байдлаар хэлэлцсэн. Хоршооны сургалтанд 2 гишүүнийг хамруулан идэвхжүүлэн идэвхгүй хоршооны тоог 1-р бууруулан 38 идэвхгүй хоршоотой болсон байна. /100/	
			Идэвхжсэн хоршоодын тоо	26	27	Сайнцагаан сумын Аравжих далай хоршоо энэ онд хоршооны тэргүүлэх гишүүд хуралдаж цаг үеийн байдлаар хэлэлцсэн. Хоршооны сургалтанд 2 гишүүнийг хамруулан идэвхжүүлэн идэвхжсэн хоршооны тоог 1-р нэмэгдүүлэн 27 идэвхжсэн хоршоотой болсон байна. /100/	
7.3	“Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр”-ийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх	УТ, ОНТ, Төсөл хөтөлбөр, Хувийн хэвшил	Дэмжлэг үзүүлсэн иргэн, ААНэгжийн тоо	15	10	Улсын төсвийн хөрөнгөөс орон нутагт төсөв хуваарилагдаагүй. “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх цогц төлөвлөгөө” – нд тусгагдсан Ажлын байрыг дэмжих зээлээс Хангда ХХК 90,0 сая төгрөгийн санхүүжилт аван үйл ажиллагаагаа явуулж байна. 2 ажлын байр шинээр бий болсон. Зээлийн батлан даалтын санд хамрагдан барьцаа хөрөнгөний 30 хувийг гаргуулсан. 2021 онд Дэлгэрцогт, Сайнцагаан, Өндөршил, Баянжаргалан, Адаацаг сумд 31 иргэн, ААНэгжид 798,5 сая төгрөгийн зээлийг олгосон байна. Хадгалагдсан ажлын байр - 42, шинээр - 24 ажлын байр бий болсон.	79
			Олгосон санхүүжилт - сая.төг	470,4	500,0		
			Шинэ ажлын байр	63	65		
7.4	МАН-н гаралтай бүтээгдэхүүн боловсруулах, уламжлалт болон дэвшилтэт техник технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлнэ. /мах, ноос, ноолуур, арьс шир, сүү сүүн бүтээгдэхүүн.../	УТ, ОНТ, Төсөл хөтөлбөр, Хувийн хэвшил	Шинээр байгуулагдсан үйлдвэрийн нийт тоо	1	2	Дэлгэрцогт, Сайнцагаан сумын сум хөгжлийн сангаас Арьс, шир боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр Ширээс хоршоонд 25,0 сая төгрөг, Өнөд ширээт ХХК-д 30,0 сая төгрөгний зээл олгогдсон. 5-6 нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн зах зээлд борлуулж 20,0 сая төгрөгний орлоготой ажилласан байна.	100

			Байнгын ажлын байрны тоо	3	5	Байнгын ажилын байрны тоо 10 болсон байна.	
8	Үхэр сүргийг үе шаттайгаар сайжруулж, аймгийн хэмжээний малын бүртгэл мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх	УТ,ОНТ	Мэдээллийн санд бүртгэгдсэн малын тоо, сайжруулагчаар ашиглах бухны тоо	21000/0	25200/6	Баянжаргалан сумын нутгийн монгол үүлдрийн 800 үхэрт хувьсийн ангилалт, ээмэгжүүлэлтийн ажил хийгдсэн ба намрын ангилалтаар 200 үхэр цөм сүргийн ангийн шаардлага хангаж, ашиг шимийн түвшин 8 %-иар нэмэгдсэн. Дорнод монголын мухар улаан үүлдрийн 10 өсвөр хээлтүүлэгчийг 150 үнээнд сайжруулагчаар ашигласан. Хээл авалт 100%-тай байна. Үржлийн малыг ээмэглэх ажлын хүрээнд 1000 тэмээ, 2000 хонь, 100 адуу, Баянжаргалан сумын цөм сүргийн 200 үхэр, нутгийн монгол 1000 хонь нийт 4300 малыг ээмэглэж ялган тэмдэглэж өмнөх оны түвшингээс 20,6 %-иар нэмэгдүүлсэн. ХХААХҮЯам нь малын бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн программыг шинэчлэн боловсруулж байгаа тул ээмэгжүүлсэн малыг бүртгэлд оруулах ажил хүлээгдэж байгаа болно.	100
8.1	Үржлийн хээлтүүлэгч, цөм сүргийн хээлтэгчийг ялган тэмдэглэж, бүртгэл мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх.	ОНТ	Малыг ялган тэмдэглэж бүртгэлжүүлсэн малын тоо	21000	25200	Үржлийн малыг ээмэглэх ажлын хүрээнд 1000 тэмээ, 2000 хонь, 100 адуу, Баянжаргалан сумын цөм сүргийн 200 үхэр, нутгийн монгол 1000 хонь нийт 4300 ээмэглэж ялган тэмдэглэж өмнөх оны түвшингээс 20,6 %-иар нэмэгдүүлсэн. ХХААХҮЯам нь малын бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн программыг шинэчлэн боловсруулж байгаа тул ээмэгжүүлсэн малыг бүртгэлд оруулах ажил хүлээгдэж байгаа болно.	100
8.2	Баянжаргалан сумын үхэр сүргийг "Дорнод монголын мухар улаан" үүлдрээр сайжруулах	ОНТ	Бойжуулсан бухны тоо	0	6	Дорнод аймгийн Халх гол сумаас Дорнод монголын мухар улаан үүлдрийн 10 бухан бяруу авах захиалгын дагуу 10 сая төгрөгний хөрөнгийг шийдвэрлэн авчирч	100

						орон нутгийн 10 малчин өрхийн 150 гаруй үхэрт сайжруулагчаар ашиглаж байна.	
9	Бэлчээрийг нөхөн сэргээх, үе шаттайгаар ашиглаж, хамгаалах	УТ, ОНТ	Шинэ болон сэргээн засварласан худгийн тоо хашиж хамгаалсан талбайн хэмжээ га	Гүн өрмийн-23, Энгийн уурхайн-19 Хашиж хамгаалсан талбай-0	Гүн өрмийн -10, Энгийн уурхайн -10 Хашиж хамгаалсан талбай -2	Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил, Шинэ хөдөө төсөл, ОНХС, малчдын хөрөнгө оруулалтаар 6 суманд 12 инженерийн хийцтэй гүн өрмийн худаг, 2 суманд 16 цооног, 5 суманд нийт 44 энгийн уурхайн худгийг сэргээн засварлан нийт 83000 га бэлчээрийг усжуулж, өмнөх оноос бэлчээр усжуулалт 0,3 хувиар нэмэгдсэн. 51,5 га бэлчээрийн талбайг хашиж хамгаалж, 15,1 га талбайд бэлчээрийн олон наст ургамал тариалсан.	100
9.1	Бэлчээр хашиж хамгаалах, олон наст ургамал тариалах.	ОНТ, Хувийн хөрөнгө оруулалт	Хашиж хамгаалсан, талбайн хэмжээ /га/ Тариалсан талбайн хэмжээ /га/	0	2/3	2021 онд Сайнцагаан сумын 3 малчин өрх өвөлжөө хаваржааны дэргэдэх 51.5 га бэлчээр хашиж хамгаалаад байна. 15,1 га талбайд бэлчээрийн олон наст ургамал тариалсан.	100
9.2	Гүн өрмийн худгийг шинээр гаргах	Төсөл хөтөлбөр, ОНТ 230.0	Шинээр гаргасан худгийн тоо	23	10	3ЗББУХТөсөл, ОНХСангийн санхүүжилтээр 4 суманд инженерийн хийцтэй гүн өрмийн 10, 2 суманд 16 цооног гаргасан.	100
9.3	Энгийн уурхайн худгийг сэргээн засварлах.	Төсөл хөтөлбөр, ОНТ	Сэргээн засварласан худгийн тоо	19	10	3ЗББУХТөсөл, ОНХСангийн санхүүжилтээр 5 суманд энгийн уурхайн 44 худгийг сэргээн засварласан.	100
9.4	Өвөлжилтийн бэлтгэл хангалт	ОНТ	Бэлтгэл хангасан хувь	70	80	Засгийн газрын 221 тогтоол Шадар сайд, ХХААХҮС-ын 01 тоот албан даалгаврын хүрээнд 2021-2022 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах, Аймгийн Засаг даргын 03 тоот албан даалгавар, ХХААГ-ын даргын зөвлөмжийг гаргаж сумдад хүргэж ажилласан. өвөлжилтийн бэлтгэл хангалт 80,8 хувьтай хангагдсан.	100

9.5	Орон нутгийн тусгай хэрэгцээний сумын болон сум дундын отрын бүс нутгийг баталгаажуулах	Төсөл хөтөлбөр, ОНТ	Отрын бүс нутгийг баталгаажуулсан байх /тийм-1 үгүй-0/	0	1	Дэлгэрхангай, Сайхан-Овоо, Эрдэнэдалай, Өлзийт сумдын сум дундын отрын бүс нутгаар 74,3 мянган га бэлчээрийн талбайн координатыг тогтоож Засаг даргын дэргэдэх зөвлөлийн болон Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хуралд танилцуулан дэмжигдсэн. Эцсийн шийдвэрийг Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Төлөөлөгчдийн VII хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлээ.	100
10	Биотехнологийн ололтыг нэвтрүүлэх.	УТ, ОНТ	Биотехнологийн ололтыг нэвтрүүлсэн малын тоо	0	500	Сайнцагаан сумын Далай багийн 3 өрхийн 400 хонинд мах-ноос-өөхний чиглэлийн Сайнцагаан омгийн хуц болон түргэн өсөлттөй махны чиглэлийн суффлок үүлдрийн хуцны үр, нутгийн монгол үхэрт өндөр ашиг шимт Сэлэнгэ үүлдрийн гүн хөлдөөсөн үрээр 17 үхэрт тус тус зохиомол хээлтүүлэг хийсэн. Мөн малын удмын сангийн үндэсний төвд Сайнцагаан омгийн 3, нутгийн монгол 3 хуцнаас 1236 тун үрийг авч хадгалуулаад байна.	84,6
10.1	Баталгаажсан Сайнцагаан омгийн хонинд зохиомол хээлтүүлэг хийх,	ОНТ	Хээлтүүлэг хийсэн малын тоо,	0	500	Сайнцагаан сумын Далай багийн 3-н өрхийн 400 хонинд, зохиомол хээлтүүлэг хийгдсэн.	80
10.2	Баталгаажсан Сайнцагаан омгийн хониноос үр авч хадгалуулах,	ОНТ	Авсан үр /тун/	0	1000	Малын удмын сангийн үндэсний төвд Сайнцагаан омгийн 3, нутгийн монгол 3-н хуцыг тус тус хүргүүлэн аваачиж 1236 тун үрийг авч хадгалуулсан.	100
10.3	Баталгаажсан омгийн малд үзлэг ангилалт хийх	УТ, ОНТ 45,0	Ангилалтанд хамрагдсан малын тоо	20 000	22000	Энэ онд улсын төсвөөр хийгддэг мал ангилалтын зардал хасагдаж ирснээс шалтгаалан 16800 малыг үзлэг ангилалтанд хамруулсан. Төрлөөр авч үзвэл: Баянжаргалан сумын 800 үхэр, Хулдын Олдохын хүрэн бор омгийн 4000 тэмээ, Сайнцагаан омгийн 4000 хонь, Өндөршилд омгийн 4000 адуу,	76,4

						Эрдэнэдалай сумын Ширгийн говийн нутгийн монгол 4000 хонинд хавар, намрын ангилалтыг технологит хугацаанд хийлээ.	
11	Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгжийг дэмжиж хамтран ажиллах.	ОНТ, хувь хөрөнгө	Шинээр байгуулсан нэгжийн тоо, хамтарч ажилласан аж ахуй нэгжийн тоо	4	4	Мал зүйч үржүүлэгчдийн холбоо, Уудам жаргалант ХХК, Хулд таван эрдэнэ ХХК-иудын үзлэг ангилалтын үйл ажиллагаанд 40,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн. Мөн малын үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний “Уул хадарганатай” ХХК шинээр байгуулагдан үйл ажиллагаа нь жигдэрсэн ба улмаар сүүний чиглэлийн ямааны фермер хөгжүүлэхээр хүсэлтээ ирүүлснийг дэмжиж албан тоот хүргүүлсэн.	100
11.1	Мал үржүүлэг, технологийн аж ахуй нэгжүүдийг дэмжиж ажиллах, шинээр үржлийн аж ахуй нэгж байгуулах	Хувь хөрөнгө, ОНТ	Шинээр байгуулсан аж ахуй нэгжийн тоо	4	1	Гурвансайхан суманд Уул хадарганатай ХХК мал үржлийн аж ахуй нэгж шинээр байгуулагдсан. Аж ахуй нэгжийн даргад нь мал үржлийн стандарт болон журмын талаар мэдээлэл гарын авлага өгсөн.	100
11.2	Бог малын хээлтүүлэгчийг үржлийн аж ахуй нэгжид ялган төвлөрүүлэх	Хувь хөрөнгө	Ялган төвлөрүүлсэн хээлтүүлэгч хувь	60	60	2020 онд хаваржилт хүндэрсний улмаас хээлтүүлэгч малын 11,7 хувь буюу 2230 хээлтүүлэгч хорогдсон. Ялган суурилсан хээлтүүлэгч хуц 2427, ухна 1701 бүгд 4128 хээлтүүлэгч мал ялган суурилсан нь нийт хээлтүүлэгч малын 23,8 % -ийг эзэлж байна.	40
ХОЁР. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ АРГА ХЭМЖЭЭ							
1	Худалдаа үйлчилгээний салбарын шинэчилсэн стандартыг мөрдүүлж хэрэгжүүлж ажиллах	УТ, ОНТ, Төсөл хөтөлбөр, Хувийн хэвшил	Стандартын хэрэгжилтийн хувь	90	95	Стандарт хэмжил зүйн хэлтэстэй хамтран MNS 5021-1:2019 жижиглэн худалдааны шинэчлэгдсэн стандартыг мөрдүүлэх, хэрэгжилтийг шалгах зорилгоор 3 удаагийн хяналт шалгалтаар аймгийн төвийн 27 хүнсний худалдаа эрхлэгч иргэн ААНэгжийн ажлын байранд нь болон болон Стандарт хэмжил зүйн хэлтсийн дэргэдэх баталгаажуулалтын орон тооны бус ажлын хэсгийн хурлын дүгнэлтээр зөвлөмж зөвлөгөөг өгч, гарын авлага материалаар	94,7

						хангаж ажиллалаа. шинэчилсэн стандартын хэрэгжилт 90 хувьтай байна.	
1.1	Хоол үйлдвэрлэл MNS 4946:2019, Худалдаа үйлчилгээний салбарт шинээр батлагдсан эрх зүйн баримт бичгийг мөрдүүлж хэрэгжүүлэх	УТ, ОНТ, Төсөл хөтөлбөр, Хувийн хэвшил	Хувь	85	90	Стандарт хэмжил зүйн хэлтэстэй хамтран MNS 4946:2019 хоолны газрын шинэчлэгдсэн стандартыг мөрдүүлэх, хэрэгжилтийг шалгах зорилгоор 2 удаагийн хяналт шалгалтаар аймгийн төвийн 28 хоол үйлдвэрлэгч иргэн ААНэгжид ажлын байранд нь болон Стандарт хэмжил зүйн хэлтсийн дэргэдэх баталгаажуулалтын орон тооны бус ажлын хэсгийн хурлын дүгнэлтээр зөвлөмж зөвлөгөөг өгч, гарын авлага материалаар хангаж ажиллалаа. шинэчилсэн стандартын хэрэгжилт 90 хувьтай байна.	100
2	“Атар-4” тариалангийн тогтвортой хөгжлийн аяны төлөвлөгөөг батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллах	УТ, ОНТ, Төсөл хөтөлбөр, Хувийн хэвшил	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	90	95	“Атар-4” тариалангийн тогтвортой хөгжлийн аяны хүрээнд орон нутагт хийх ажлын 2021 оны төлөвлөгөөг 1 зорилт 7 арга хэмжээг төлөвлөн батлуулж, хэрэгжилт 76,2 хувьтай байна.	80,2
2.1	Төмс хүнсний ногооны зоорийг барьж, ашиглалтанд оруулах.	ОНТ, Төсөл хөтөлбөр	Шинээр ашиглалтанд орсон зоорины тоо	-	1	Сайнцагаан суманд Хүнсний ногооны зоорийг Зах зээл, бэлчээрийн удирдлага хөгжил төслөөс 84,0 сая, Орон нутгийн хөгжлийн сангаас 36.0 сая төгрөгний санхүүжилттэйгээр барьж, ашиглалтанд орууллаа.	100
3	Жижиг дунд бизнес эрхлэгчдэд салбарын холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг сурталчлах.	УТ,ОНТ, Төсөл хөтөлбөр, Хувийн хэвшил	Иргэн ААНэгжийн тоо	34	40	17 ААНэгж холбогдох материалаа бүрдүүлэн өгч бичил бизнес эрхлэгч гэсэн тодорхойлолт авснаар нийт 51 бичил бизнес эрхлэгчтэй болоод байна.	100
3.1	“Дундговь түншлэл 2021” үзэсгэлэн худалдаа зохион байгуулж, бүс, улсын болон олон улсын үзэсгэлэн	УТ, ОНТ, Төсөл	Оролцогчдын тоо,	94/33,0	100/35,0	JSI олон улсын байгууллагатай хамтран зохион байгуулсан “Бизнес эрхлэгчийн бүтээгдэхүүний танилцуулга” үзэсгэлэн	38,4

	худалдаанд оролцогчдод дэмжлэг үзүүлэх	хөтөлбөр, Хувийн хэвшил	борлуулалтын орлого /сая төг/			худалдаа, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрт хамрагдсан иргэдийг хамруулсан “Алтан намар-2021” үзэсгэлэн худалдаа, Улаанбаатар хотод болсон Намрын ногоон өдрүүд үзэсгэлэн худалдаа, Өвөрхангай аймагт Монголын үйлдвэрлэл үйлчилгээний хоршоодын холбоо “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийн хаалтын семинарын үеэр зохион байгуулагдсан үзэсгэлэн худалдаа, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдөрт зориулсан өдөрлөг арга хэмжээнд санхүүгийн дэмжлэгт хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаанд нийт 53 иргэн аж ахуйн нэгж байгууллага хамрагдаж 8,3 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан байна. Намрын ногоон өдрүүд үзэсгэлэн худалдаанаас “Тэмээний ноосон хөнжил”, “Даршилсан хөмүүл” шалгарч орон нутгийн брэнд бүтээгдэхүүний тоог нэмэгдүүллээ.	
4	Малчдыг соён гэгээрүүлэх арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулах	ОНТ, Төсөл хөтөлбөр	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	0	2	“Малчдад зориулсан соён гэгээрүүлэх аян”-ы хүрээнд 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр байгууллагын үйл ажиллагаагааг сурталчлах “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг Цагаандэлгэр суманд зохион байгуулж өдөрлөгт 14 сумын 73 өрхийн 142 иргэн оролцлоо.	70
4.1	Уламжлалт мал маллагааны аргыг сэргээх, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, соён гэгээрүүлэх зорилгоор “Аймгийн /малчдын/ /тэмээчдийн/ зөвлөгөөн”-ийг зохион байгуулах.	ОНТ	Зохион байгуулсан эсэх Тийм-1 Үгүй-0	0	1	“Малчдад зориулсан соён гэгээрүүлэх аян”-ы хүрээнд 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр байгууллагын үйл ажиллагаагааг сурталчлах “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг Цагаандэлгэр суманд зохион байгуулж өдөрлөгт 14 сумын 73 өрхийн 142 иргэн оролцлоо. Нээлттэй хаалганы өдөрлөгөөр иргэдэд мэдээ мэдээлэл, төрийн зарим үйлчилгээг хүргэснээс гадна Цагаандэлгэр	100

						сумын Дэлгэрэх зам багийг жишиг болгон "Мал бүртгэлжүүлэлтийн аян"-ыг эхлүүлж нийт 770 бод, 15175 бог малын хээлтэгчийг 100 хувь ялган тэмдэглэж, бүртгэлжүүлжээ.	
4.2	“Шилмэл мал-2021” үзэсгэлэн худалдаа зохион байгуулах	5,000 000	Зохион байгуулсан эсэх Тийм-1 Үгүй-0	0	1	Малын гоц халдварт өвчний гаралт болон дэлхий нийтээр тархаад байгаа цар тахал Ковид-19 улмаас тус арга хэмжээ зохион байгуулагдаагүй.	0
5	Бэлчээрт эрсдэл учруулж буй гадны нөлөөллийг бууруулж доройтлыг багасгах.	УТ, ОНТ	Хортон мэрэгчтэй тэмцсэн талбайн хэмжээ /мян.га/, Эдийн засгийн эргэлтэнд оруулсан малын тоо /хувь/	100/28	30/20	Улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилтээр 7-н сумын 20,0 мянган га бэлчээрийн талбайд микробиологийн аргаар, мөн 7-н сумын 50,0 мянган га бэлчээрийн талбайд энгийн механик аргаар үлийн цагаан оготнотой тэмцэх ажлыг зохион байгуулсан. Нийт 170,0 мянган га талбайд тэмцсэн хээрийн техникийн үр дүн 83,6 хувь байна. Таваарын болон үржилд тэнцээгүй нийт мал буюу 748,5 мянган малаас 249,3 мянган малыг эдийн засгийн эргэлтэд оруулсан бөгөөд хэрэгцээний сүргийн 33,3 хувийг хэрэгцээлээд байна.	100
5.1	Бэлчээрийн хортон мэрэгч амьтан, шавьжтай байгаль орчин, хүн, малд халгүй технологи ашиглан тэмцэх ажлыг зохион байгуулах.	УТ, ОНТ	Бэлчээрийн хортонтой тэмцсэн талбайн хэмжээ /мян.га/	100,0	30,0	ХХААХҮС-ын 2021 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/76 тушаал, аймгийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/146 захирамжаар Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 7 сумын 20,0 мянган га бэлчээрийн талбайд микробиологийн аргаар, мөн 7 сумын 50,0 мянган га бэлчээрийн талбайд энгийн механик аргаар үлийн цагаан оготнотой тэмцэх ажлыг зохион байгуулсан. Нийт 170,0 мянган га талбайд тэмцсэн хээрийн техникийн үр дүн 83,6 хувь байна.	100
5.2	Бэлчээрийн даацаас илүү гарсан малыг эдийн засгийн эргэлтэд оруулах	ОНТ	Эдийн засгийн эргэлтэнд	28,4	20	Таваарын болон үржилд тэнцээгүй 748,5 мянган малаас 249,3 мянган малыг эдийн засгийн эргэлтэд оруулсан бөгөөд	100

			орсон малын тоо хувь			хэрэгцээний сүргийн 33,3 хувийг хэрэгцээлээд байна. Өвлийн идэш арга хэмжээний хүрээнд 218 тн мах бэлтгэн нийлүүлж, 1,3 тэр бум төгрөгний борлуулалтын орлоготой ажилласан.	
Зорилтын тоо -16, хэрэгжилтийн хувь							95,6
Арга хэмжээний тоо-43, хэрэгжилтийн хувь							90,8
Ерөнхий үнэлгээний хувь							93,2

ХЯНАСАН:

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГА

(албан тушаал)

(гарын үсэг)

Б.МӨНХЖАРГАЛ

(гарын үсгийн тайлал)

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ДАХШУ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

(албан тушаал)

(гарын үсэг)

О.ГАНЦЭЦЭГ

(гарын үсгийн тайлал)